



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар хөгжил тохижилт ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/10-НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: А.Гэрэлмаа Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3. Аудитын тайлан.....	Error! Bookmark not defined.
3.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
3.2 Дотоод хяналт.....	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал.....	Error! Bookmark not defined.
3.4 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	11
4.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
8. Аудитын илрүүлэлт.....	18
8.1 Залруулсан алдаа.....	18
8.2 Төлбөрийн акт.....	Error! Bookmark not defined.
8.3 Албан шаардлага.....	18
8.4 Зөвлөмж.....	20
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
НД	Нийгмийн даатгал



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № СЭА-2022/10-НА-СТА-ОНА

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

- Үйлдвэрийн газрын 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй.
- Шатахууны 80,491.6 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг гарсан тухай бүр бус сарын эцэст бөөн дүнгээр бүртгэсэн, шаардах хуудас, шатахуун олгох баримтад зөвшөөрсөн, олгосон, хүлээн авсан хүний гарын үсэг бүрэн зурагдаагүй, тоо хэмжээг бичээгүй зэрэг хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан, нягтлан бодох бүртгэлийг холбогдох, стандарт, хууль тогтоомжийн дагуу хөтлөөгүй.

- Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс нийгмийн даатгалын 11 сарын тайланд 41 ажилтны 28,697.8 мянган төгрөгийн цалинг зөрүүтэй тайлагнасан, жилийн эцэст татвар, нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй.
- Шууд худалдан авах босго үнээс давсан 60,000.1 мянган төгрөгийн нөөцийн махны худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно" гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байдал", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	73,023,501.12	74,030,921.17
1.1.2	Дансны авлага	145,505,771.69	108,527,601.81
1.1.6	Бараа материал	255,218,790.71	254,030,675.97
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,726,000.00	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	477,474,063.52	436,589,198.95
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	7,654,051,886.07	9,997,361,811.45
1.2.2	Биет бус хөрөнгө	464,973,260.28	465,747,637.78
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,119,025,146.35	10,463,109,449.23
1.3	Нийт хөрөнгийн дүн	8,596,499,209.87	10,899,698,648.18
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	75,404,105.21	713,730.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	81,171,493.90	22,089,092.64
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	156,575,599.11	22,802,822.64
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Өмч	2,198,470,689.71	2,198,470,689.71
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,501,045,384.62	3,501,045,384.62
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	5,454,841,045.49	9,301,913,718.91
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,714,433,509.06)	(4,124,533,967.70)
2.3.11	Эздийн өмчийн дүн	8,439,923,610.76	10,876,895,825.54
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	8,596,499,209.87	10,899,698,648.18

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	704,577,732.79	1,273,041,677.41
2	Борлуулалтын өртөг	-	60,708,508.00
3	Нийт ашиг (алдагдал)	704,577,732.79	1,212,333,169.41
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,914,876,105.21	2,666,572,541.51
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	(29,190,132.29)	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,239,488,504.71)	(1,454,239,372.10)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,239,488,504.71)	(1,454,239,372.10)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,239,488,504.71)	(1,454,239,372.10)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	10,697,530,244.82	-	-	(1,474,945,004.35)	9,222,585,240.47
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	456,826,875.00	-	-	-	456,826,875.00
2	Залруулсан үлдэгдэл	11,154,357,119.82	-	-	(1,474,945,004.35)	9,679,412,115.47
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,239,488,504.71)	(1,239,488,504.71)
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
8	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	11,154,357,119.82	-	-	(2,714,433,509.06)	8,439,923,610.76
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	3,847,072,673.42	-	-	-	3,847,072,673.42
2	Залруулсан үлдэгдэл	15,001,429,793.24	-	-	(2,714,433,509.06)	12,286,996,284.18
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,410,100,458.64)	(1,410,100,458.64)
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	15,001,429,793.24	-	-	(4,124,533,967.70)	10,876,895,825.54

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Орлогын нийт дүн	704,577.7	977,579.0	1,273,041.7	(295,462.7)	130.2%
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	274,425.6	474,500.0	574,332.2	(99,832.2)	121.0%
2	Татаас, санхүүжилт /Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг/	430,152.1	130,478.0	159,432.1	(28,954.1)	122.2%
3	Санхүүжилт /Хог тээвэр/		347,449.7	340,137.6	7,312.1	97.9%
4	Бусад татаас, санхүүжилт		25,151.3	199,139.8	(173,988.5)	791.8%
	Нийт зардлын дүн	1,944,066.2	973,378.4	2,666,572.5	(1,693,194.2)	274.0%
1	Цалин хөлс болон нэмэгдэл цалин	407,939.1	372,239.7	553,753.6	(181,514.0)	148.8%
2	Нэмэгдэл урамшил		12,529.7	-	12,529.7	0.0%
3	Хоол, унааны зардал		945.0	-	945.0	0.0%
4	Нийгмийн даатгал шимтгэл	55,571.2	70,089.3	80,795.9	(10,706.6)	115.3%
5	Гэрэл цахилгаан	84,539.6	120,100.0	133,889.3	(13,789.3)	111.5%
6	Түлш, халаалт	45,238.7	95,222.5	73,113.3	22,109.2	76.8%
7	Цэвэр бохир ус	17,773.1	27,120.0	18,231.6	8,888.5	67.2%
8	Бичиг хэрэг	977.2	2,536.5	3,706.5	(1,170.0)	146.1%
9	Тээвэр, шатахуун	68,218.5	44,127.2	83,301.9	(39,174.7)	188.8%
10	Шуудан холбоо	2,431.8	2,616.0	2,739.2	(123.2)	104.7%
11	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал, цэвэрлэгээ	3,596.8	76,388.5	12,360.4	64,028.1	16.2%
12	Маягт, үнэт цаас хэвлүүлэх зардал		3,100.0	-	3,100.0	0.0%
13	Дотоод албан томилолт	1,551.4	-	1,109.8	(1,109.8)	0.0%
14	Аудитын төлбөр		100.0	1,800.0	(1,700.0)	1800.0%
15	Хөдөлмөр хамгааллын зардал		3,500.0	30,474.0	(26,974.0)	870.7%
16	Нормын хувцас, зөөлөн эдлэл		5,086.4	287.5	4,798.9	5.7%
17	Урсгал засвар	39,300.5	48,862.5	23,797.3	25,065.2	48.7%
18	Хангамжийн материал	3,211.7	4,500.0	16,200.0	(11,700.0)	360.0%
19	Банкны шимтгэл	146.3	-	174.2	(174.2)	0.0%
20	Даатгалын үйлчилгээ	1,800.0	8,616.0	7,506.8	1,109.2	87.1%
21	Тээврийн хэрэгслийн оношилгоо		304.0	110.0	194.0	36.2%
22	Тээврийн хэрэгслийн татвар		330.0	-	330.0	0.0%
23	Сэлбэг, материалын зардал		-	31,220.8	(31,220.8)	0.0%
24	Үл хөдлөх хөрөнгийн татвар	57.4	27,545.1	-	27,545.1	0.0%
25	Бусад албан татварын зардал		44,400.0	22,962.3	21,437.7	51.7%
26	Шагнал урамшууллын зардал		-	1,230.0	(1,230.0)	0.0%
27	Ахмад настнуудад олгосон тэтгэмж		1,120.0	1,350.0	(230.0)	120.5%
28	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,972.2	2,000.0	11,212.7	(9,212.7)	560.6%
29	Элэгдлийн зардал	1,165,517.5	-	1,555,245.5	(1,555,245.5)	0.0%
30	ББӨ		-	60,708.5	(60,708.5)	0.0%
	Ашиг, алдагдал	(1,239,488.5)	4,200.6	(1,454,239.4)	1,458,440.0	-34619.7%

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ нь “Иргэд үйлчлүүлэгчдийн ая тухтай үйлчлүүлэх цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж ажиллах” гэсэн эрхэм зорилготойгоор тайлант онд үйл ажиллагаа явуулсан байна.

“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын орон нутгийн өмчит худалдааны төвийг удирдлага зохицуулалтаар хангаж, худалдааны төвийн тохижилт, түүний ашиглалт, хамгаалал засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх хяналт тавих,
- Худалдааны төвд үйл ажиллагаа явуулах иргэн, байгууллагатай гэрээ хийх, байр талбайг ашиглуулах, ашиглалтын төлбөр тооцоог хийх,
- Орон нутгийн өмчийн тээврийн хэрэгслээр аймгийн төвд эрх бүхий байгууллагын тогтоосон чиглэл, хуваарь, үнэ тарифаар нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх, төсвийн байгууллагад захиалгат үйлчилгээг тогтоосон үнэ тарифаар үзүүлэх,
- Орон нутгийн өмчийн мал нядалгааны цэг, махны хөргүүрт зоорины ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх,
- Эрх бүхий байгууллага албан тушаалтны шийдвэрийн дагуу аймгийн махны нөөцийг бүрдүүлэх, хадгалах, түгээх ажил үйлчилгээг эрхлэх,
- Сүхбаатар сумын нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, түүний засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх,
- Иргэн, аж ахуйн нэгж, төр төсвийн байгууллага, сум орон нутгийн хөгжилд зориулсан тохижилт, хог хаягдлыг тээвэрлэх, устгах, боловсруулах ажил үйлчилгээ эрхлэх,
- Сүхбаатар сумын ногоон байгууламжийн үйлчилгээний төлөвлөлт, бодлогыг боловсруулж, менежментийг сайжруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Мод үржүүлгийн үйл ажиллагааг эрхлэх,
- Ногоон байгууламж, байгаль орчны талаар баримтлах бодлого, хууль тогтоомж, хэтийн болон ойрын зорилтын дагуу сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх,

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ААТҮГ статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутаг, эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Сүхбаатар сумын ИТХТ-ийн 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоолоор “Сүхбаатар хөгжил, тохижилт” ААТҮГ-ыг байгуулсан байна. Аймгийн ИТХТ-ийн 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор СЭА-2022/10-НА-СТА-ОНА

“Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ыг татан буулгаж “Сүхбаатар хөгжил, тохижилт” ОНӨААТҮГ-т нэгтгэсэн байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх”, 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор “Айл өрхийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамж”-ийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх,
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дугаар тогтоол “ТБОНӨБАҮ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай” гэх мэт.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,303,199.4 мянган төгрөгөөр буюу 26.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	73,023.5	74,030.9	1,007.4

/мянган төгрөг/

Дансны авлага	145,505.8	108,527.6	(36,978.2)
Бараа материал	255,218.8	254,030.7	(1,118.1)
Урьдчилж төлсөн зардал	3,726.0	-	(3,726.0)
Үндсэн хөрөнгө	8,119,025.1	10,463,109.4	2,344,084.3
Нийт хөрөнгө	8,596,499.2	10,899,698.6	2,303,199.4
Өр төлбөр	156,575.6	22,802.8	(133,772.8)
Эздийн өмч	11,154,357.1	15,01,429.8	3,847,072.7
Хуримтлагдсан ашиг/+, алдагдал/-/	2,714,433.5	4,124,533.9	(1,410,100.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,596,499.2	10,899,698.6	2,303,199.4

Байгууллагын мөнгөн хөрөнгийн данс 74,030.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдаж, өмнөх оноос 1,007.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд касс болон харилцахаар 1,434,976.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,433,969.0 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 93.1 хувь нь нөөцийн мах бэлтгэх зориулалттай 68,898.5 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 108,527.6 мянган төгрөг болж 36,978.2 мянган төгрөгөөр буурсан нь түрээсийн авлага буурснаас голлон шалтгаалсан байна. Нийт авлагын 49.9 хувийг буюу 54,168.3 мянган төгрөгийг түрээсийн авлага, 36.2 хувийг буюу 39,338.9 мянган төгрөгийг нөөцийн махны авлага, 6.8 хувийг буюу 7,356.2 мянган төгрөгийг хувь хүмүүсээс авах авлага, 5.5 хувийг буюу 6,008.5 мянган төгрөгийг бусад авлага, 1.4 хувийг буюу 1,532.7 мянган төгрөгийг ажилтнуудаас авах авлага, 0.1% буюу 123.0 мянган төгрөгийг байгууллагаас авах авлага эзэлж байна

Авлагын үлдэгдэлд хугацаа хэтэрсэн, эзэн холбогдогч тодорхойгүй, насжилт өндөртэй нөөцийн махны 38,762.0 мянган төгрөгийн найдваргүй авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл 254,030.7 мянган төгрөг болж өмнөх оноос 1,118.1 мянган төгрөгөөр буурсан нь өөрийн хөрөнгөөр 60,000.1 мянган төгрөгийн нөөцийн мах, 32,767.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, 21,112.3 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 80,665.5 мянган төгрөгийн түлш шатах тослох материал, 5,810.1 мянган төгрөгийн хангамжийн материал, 57,608.5 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авч, 259,151.7 мянган төгрөгийн бараа материалыг худалдан борлуулсан болон зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 3,125,256.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд өөрийн хөрөнгөөр 3,750.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж /хөргөгч, печь, принтер/, 3,771.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил /шүүгээ/ худалдан авч, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,392,710.3 мянган төгрөгийн Сайхны хөтлийн 7 км авто зам, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 49,366.1 мянган төгрөгийн 6-р багийн явган хүний зам, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 19,000.0 мянган төгрөгийн 3-р багийн гэрэлтүүлэг, 19,751.6 мянган төгрөгийн 6-р багийн гэрэлтүүлэг зэрэг нийт 3,480,828.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгаснаас шалтгаалсан байна.

Тайлант онд 727,149.0 мянган төгрөгийн анхны үнэ бүхий “0” үлдэгдэлтэй хөрөнгийн ашиглах хугацааг шинээр тогтоосон байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 22,802.8 мянган төгрөг болж өмнөх оноос 133,772.8 мянган төгрөгөөр буурсан байна. Өр төлбөр дансны 3.1 хувийг буюу 713.7 мянган төгрөгийг байгууллагад өгөх өглөг, 96.9 хувийг буюу 22,089.1 мянган төгрөгийг татварын өглөг тус тус эзэлж байна.

Хуримтлагдсан ашиг/ алдагдал / дансны үлдэгдэл (4,124,533.9) мянган төгрөг болж, өмнөх оноос алдагдал 1,410,100.4 мянган төгрөгөөр өсөхөд тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

3.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ-нь 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулалгүйгээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд гүйцэтгэлээр 1,273,041.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,727,281.1 мянган төгрөгийн зардал гарган, 1,454,239.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Орлогыг дараах эх үүсвэрээс бүрдүүлжээ. Үүнд:

- Түрээсийн орлого 467,540.1 мянган төгрөг,
- Нөөцийн махны орлого 61,701.7 мянган төгрөг,
- Нийтийн тээврийн орлого 2,181.3 мянган төгрөг,
- Сайхны хөтлийн орлого 9,560.0 мянган төгрөг,
- Ковш түрээсийн 7,891.0 мянган төгрөг,
- Нядалгааны орлого 22,093.0 мянган төгрөг,
- Бусад орлого 3,364.9 мянган төгрөг,
- Нийтийн тээвэр, гэрэлтүүлгийн татаас санхүүжилтийн орлого 159,432.1 мянган төгрөг,
- Хог тээврийн санхүүжилтийн орлого 340,137.6 мянган төгрөг,
- Түрээсийн төлбөрийн зөрүүд олгосон санхүүжилт 180,484.4 мянган төгрөг,
- Бусад татаас, санхүүжилт 18,655.4 мянган төгрөг.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Сүхбаатар хөгжил СЭА-2022/10-НА-СТА-ОНА

тохижилт Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /цаашид Сүхбаатар хөгжил тохижилт ААТҮГ гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн бараа материалын тайланд НӨАТ-ыг салган бүртгэх, байгууллагын бүртгэлд байгаа тээврийн хэрэгслийн гэрчилгээг өөрийн эзэмшилд бүртгүүлэх тухай болон төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарын аудитор А.Гэрэлмаа, аудиторын туслах З.Азжаргал нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 68 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө муутай гэж дүгнэж байна. Үүнд:

- 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, үйлдвэрийн газрын бүтэц, орон тоо, зохион байгуулалт, цалингийн хэмжээг боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтнаар батлуулаагүй,
- Үйлдвэрийн газрын тайлант жилийн үйл ажиллагааны үр дүнг тайлагнаж, үнэлэлт дүгнэлт хийлгээгүй байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн байна.

“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ-ын хувьд захирлын 2021 оны А/11 тушаалаар дотоод хяналт шалгалтын комиссыг орон тооны бус 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, байгууллагын “Дотоод хяналт шалгалтын журам”-ыг баталсан бөгөөд тайлант жилийн хугацаанд ажлын төлөвлөгөөг батлуулаагүй, хяналт шалгалт хийгдээгүй байна.

ТЕЗ-ийн дотоод аудит болох аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас санхүүгийн хяналт, шалгалт хийгдээгүй байна.

4.3 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогын 1,272,041.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,720.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 111 мэдээллийг хугацаанд нь, 28 мэдээллийг хугацаа хоцроож, 9 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, ...цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасныг зөрчин 2,015.0 мянган төгрөгийг бэлэг, шагнал урамшуулалд зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт тогтоож, 6 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өгснөөс төлбөрийн актыг барагдуулж, албан шаардлага, зөвлөмж 63.6 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	504.6	1	504.6	-	-	100
Албан шаардлага	6	47,784.5	4	31,530.3	2	16,254.2	66.7
Зөвлөмж	4	12,697.6	2	7,649.1	2	5,048.5	50
Нийт дүн	11	60,986.7	7	39,684.0	4	21,302.7	63.6

Өмнөх аудитаар өгсөн санхүүгийн тайлан гаргахын өмнө НД-ын байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах, Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь ил тод, бүрэн мэдээлэх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд нийгмийн даатгалд 28,697.8 мянган төгрөгийн цалинг зөрүүтэй тайлагнасан, шилэн дансанд 28 мэдээллийг хугацаа

хоцроож, 9 мэдээллийг огт мэдээлээгүй зэрэг зөрчлүүдийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр 2021 оны үйлдвэрлэлийн болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй, шатахууны 80,491.6 мянган төгрөгийн гүйлгээг санхүүгийн программд сар бүр бөөн дүнгээр шивсэн, шаардах хуудас, шатахуун олгох баримтад зөвшөөрсөн, олгосон хүлээн авсан хүний гарын үсэг дутуу, тоо хэмжээг бичээгүй зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг хийж нягтлан бодох бүртгэлийг холбогдох, стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй зэрэг зөрчлийг арилгах албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу хариуцлага тооцуулах албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 3,852,405.3 мянган төгрөгийн шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.
2. Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлгүй, улсын дугааргүй, техник хяналтын үзлэгт хамрагдаагүй, бүрэн бус Портер маркийн тээврийн хэрэгслээр хог тээврийн ажил үйлчилгээ үзүүлж байгаа нь Авто тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1. “Автотээврийн хэрэгслийн хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд нөлөө үзүүлэх сөрөг хүчин зүйлсийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд жилийн турш техникийн хяналт хийж гэрчилгээ олгоно.”, 17.2. “Техникийн хяналтын үзлэг хийсэн гэрчилгээнд заасан хугацаанд техникийн хяналтад ороогүй автотээврийн хэрэгслийг /байлдааны тусгай зориулалттайгаас бусад/ замын хөдөлгөөнд оролцохыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд бүрэн бус тээврийн хэрэгслийг техник хяналтын үзлэгт хамруулан, шаардлага хангасан нөхцөлд бичиг баримтыг бүрдүүлэн, данс бүртгэлд авах нь зүйтэй юм.

3. Байгууллагын зарлагын гүйлгээг интернет банк ашиглан хийж гүйцэтгэсэн бөгөөд гүйлгээ хийх эрх нь нягтлан бодогчид зөвшөөрөгдсөн байна. Энэ нь ажил гүйлгээ, хөрөнгө мөнгөний зарцуулалтад удирдлагын зүгээс тавих хяналт алдагдах эрсдэлтэй байгаа тул гүйлгээний эрхийг байгууллагын удирдлага, нягтлан бодогч хамтран хэрэгжүүлэх шаардлагатай байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 411,214.2 мянган төгрөгийн 15 алдаа зөрчил илэрснээс 83,890.3 мянган төгрөгийн 6 алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 183,028.8 мянган төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 144,294.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй, материаллаг 320,004.2 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 12,720.7 мянган төгрөгийн түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 83,890.3 мянган төгрөгийн 6 алдааг залрууллаа. Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд 1,864.4 мянган төгрөгийн түрээсийн орлогыг дутуу тусгасан,
- Бараа материалын дансанд 2,324.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил бүртгэсэн,
- Машин тоног төхөөрөмжийн данснаас "0" үлдэгдэлтэй 14 нэр төрлийн 23ш 14,279.5 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглах хугацааг сунган дахин үнэлж хасагдуулсан боловч орлогоор бүртгээгүй,
- Орлогын дэлгэрэнгүй тайланд 23,599.7 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг бүртгэснээс зардал илүү тайлагнагдсан,
- ХХОАТ-ын өглөгийн дансанд 30,644.0 мянган төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, 4,264.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн татвар, 165.7 мянган төгрөгийн орлогын албан татварыг бүртгэсэн,
- Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн 6,748.3 мянган төгрөгийг үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр тусгасан зэрэг алдааг тус тус залруулав.

8.2 Албан шаардлага:

1. Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

- Үйлдвэрийн газрын 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “*Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*”, Сүхбаатар хөгжил тохижилт ААТҮГ-ын дүрмийн 8 дугаар зүйлийн

8.1.1 дэх “ үйлдвэрийн газрын үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, **сумын засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллах**” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Шатахууны 80,491.6 мянган төгрөгийн гүйлгээг санхүүгийн программд сар бүр бөөн дүнгээр шивсэн, шаардах хуудас, шатахуун олгох баримтад зөвшөөрсөн, олгосон, хүлээн авсан хүний гарын үсэг бүрэн зурагдаагүй, тоо хэмжээг бичээгүй зэрэг хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан, нягтлан бодох бүртгэлийг холбогдох, стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь “**Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна**”, 13.6 дахь “**Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна**”, 13.7 дахь “**Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно**” 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “**Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах**” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүйгээс алдаа, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах болон алдаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

2. Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс нийгмийн даатгалын 11 сарын тайланд 41 ажилтны 28,697.8 мянган төгрөгийн цалинг зөрүүтэй тайлагнасан, жилийн эцэст татвар, нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх “**Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх**”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “**Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах**”, 20.2.6 дахь “**... тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах**” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрүүтэй тайлагнасан цалин хөлсийг 2022 оны эхний хагас жилд багтаан холбогдох байгууллагуудтай дахин тооцоо нийлж, тулган баталгаажуулах албан шаардлага хүргүүлэх.

3. Шууд худалдан авах босго үнээс давсан 60,000.1 мянган төгрөгийн нөөцийн махны худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг шууд худалдан авах аргаар гүйцэтгэж Жаргалант мах импекс ХХК-иас худалдан авсан ба анхан шатны баримт нь төлбөрийн цахим системд шивэгдээгүй байгаа нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 8

дугаар зүйлийн 8.4 дэх “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, “Босго үнэ батлах тухай” Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралтын 2 дахь “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа 10,0 сая төгрөг” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаанд босго үнийн журмыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4. Үйлдвэрийн газрын ажиллагсдыг төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээгээр цалинжуулж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд **13,839.3 мянган** төгрөг олгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 “Захирал дараах үүрэгтэй”, 20.4 “*үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох;*” Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрийн газрын орон тоо, цалин, хөлсийг сумын ИТХ-аар тогтоолгож, батлуулах албан шаардлага хүргүүлэх.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материал, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Бараа материалын тайланд НӨАТ-ыг салгаж бүртгээгүйгээс 40,252.5 мянган төгрөгийн мөнгөн орлогыг зөрүүтэй тайлагнан зардалд тусгаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх “*Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*”, 20.2.5 “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, 20.2.6-д “*... тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлд бараа материал, НӨАТ-ыг холбогдох, стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулж байх.

2. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

2.1 Илрүүлэлт: Тайлант онд 99,042.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтын гүйлгээг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д *“Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”* гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь *“Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”* гэсэн заалттай нийцээгүй бөгөөд *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

3. Тээврийн хэрэгслийн эзэмшилтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Тус байгууллагын хог тээвэрт ашиглагдаж байгаа 5,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий 81-09СЭУ улсын дугаартай Bongo Frontier маркийн тээврийн хэрэгслийг байгууллагын эзэмшилд бүртгүүлээгүй байгаа нь Авто тээврийн тухай хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх *“Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ”* гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын бүртгэлд байгаа тээврийн хэрэгслийг өөрийн эзэмшилд шилжүүлэн бүртгүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
						Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар															
1	“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ	СЭА-2022/10-НА-СТА-ОНА	Нягтлан бодох бүртгэлийг холбогдох, стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй.	1	80,491.6					1	80,491.6				
2	“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ	СЭА-2022/10-НА-СТА-ОНА	2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй байна	1	-					1					
3	“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ	СЭА-2022/10-НА-СТА-ОНА	Шууд гэрээгээр худалдан авах босго үнээс давсан худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн.	1	60,000.1					1	60,000.1				
4	“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ	СЭА-2022/10-НА-СТА-ОНА	Татвар, НД-ын байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй.	1	28,697.8					1	28,697.8				
5	“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ	СЭА-2022/10-НА-СТА-ОНА	Үйлдвэрийн газрын ажиллагсдыг төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээгээр цалинжуулж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон.	1	13,839.9					1	13,839.9				
6	“Сүхбаатар хөгжил	СЭА-2022/10-НА-СТА-ОНА	Бараа материалын тайланд НӨАТ салгаж	1	40,252.5									1	40,252.5

СЭА-2022/10-НА-СТА-ОНА

Сүхбаатар хөгжил тохижилт ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудит

	тохижилт” ААТҮГ		орлогыг зөрүүтэй тайлагнасан															
7	“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ	СЭА- 2022/10-НА- СТА-ОНА	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан	1	-										1	-		
8	“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ	СЭА- 2022/10-НА- СТА-ОНА	Бараа материалын худалдан авалтын гүйлгээг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна	1	99,042.2												1	99,042.2
9	“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ	СЭА- 2022/10-НА- СТА-ОНА	Байгууллагын хог тээвэрт ашиглагдаж байгаа 81-09СЭҮ улсын дугаартай BongoFrontier маркийн тээврийн хэрэгслийг байгууллагын нэр дээр бүртгүүлээгүй байна.	1	5000.0												1	5,000.0
10	“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ	СЭА- 2022/10-НА- СТА-ОНА	Орлогын дэлгэрэнгүй тайланд түрээсийн орлогыг дутуу тусгасан	1	1,864.4	1	1,864.4											
11	“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ	СЭА- 2022/10-НА- СТА-ОНА	Бараа материалын дансанд тавилга эд хогшил бүртгэсэн	1	2,324.7	1	2,324.7											
12	“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ	СЭА- 2022/10-НА- СТА-ОНА	Машин тоног төхөөрөмжийн данснаас “0” үлдэгдэлтэй хөрөнгийг ашиглах хугацааг сунган дахин үнэлж хасагдуулсан боловч орлогоор бүртгээгүй	1	14,279.5	1	14,279.5											
13	“Сүхбаатар хөгжил тохижилт” ААТҮГ	СЭА- 2022/10-НА- СТА-ОНА	Орлогын дэлгэрэнгүй тайланд ХХОАТ-ын өглөгийг бүртгэсэнээс	1	23,599.7	1	23,599.7											

Сүхбаатар хөгжил тохижилт ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудит

			зардал тайлагнагдсан														
14	"Сүхбаатар хөгжил тохижилт" ААТҮГ	СЭА-2022/10-НА-СТА-ОНА	ХХОАТ-ын өглөгийн дансанд бусад татварыг бүртгэсэн.	1	35,073.6	1	35,073.6										
15	"Сүхбаатар хөгжил тохижилт" ААТҮГ	СЭА-2022/10-НА-СТА-ОНА	Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн 6,748.3 мянган төгрөгийг үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр тусгасан	1	6,748.3	1	6,748.3										
ДҮН				15	411,214.4	6	83,890.3	-	-	5	183,029.4	1	-	3	144,294.7		
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																	
1	"Сүхбаатар хөгжил тохижилт" ААТҮГ	СЭА-2022/10-НА-СТА-ОНА	Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс шилэн дансанд нийт мэдээлбэл зохих 148 мэдээллээс 9 мэдээлээгүй, 28 хугацаа хоцроож мэдээлсэн байна	1						1	-	-	-				
2	"Сүхбаатар хөгжил тохижилт" ААТҮГ	СЭА-2022/10-НА-СТА-ОНА	Захирлын 2021 оны А/19, А/20 дугаар тушаалаар ой тэмдэглэн өнгөрүүлэх, шагнал урамшууллын зардал гаргасан.	1	2,015.0			1	2,015.0								
ДҮН				1	2,015.0			1	2,015.0	1	-	-	-				
НИЙТ ДҮН				17	413,229.4	6	83,890.3	1	2,015.0	6	183,029.4	1	-	3	144,294.7		